



МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 07-03 өдөр

Дугаар 103

Улаанбаатар

Дүрэм батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, Засгийн газрын 2018 оны "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Сум, дүүрэг дэх мал эмнэлгийн тасгийн дүрэм"-ийг хавсралтаар баталсугай
2. Аймаг, нийслэлийн сум, дүүрэг дэх мал эмнэлгийн тасагт энэхүү дүрмийг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ТҮМЭНДЭМБЭРЭЛ

Мал эмнэлгийн ерөнхий газрын
дарын 2020 оны 07 дүгээр сарын
03 ны өдрийн 103 тоот тушаалын
хавсралт

СУМ, ДҮҮРЭГ ДЭХ МАЛ ЭМНЭЛГИЙН
ТАСГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмээр Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4, 8 дугаар зүйлийн 8.2, 28 дугаар зүйлийн 28.1, 28.4, 28.7.3 дэх хэсэгт заасан сум дүүрэг дэх мал эмнэлгийн тасгийн үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Сум, дүүрэг дэх мал эмнэлгийн тасаг нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Эм, эмнэлгийн хэрэгсэлийн тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үнийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай, Төрийн албаны тухай, Төрийн хяналт, шалгалтын тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан захиргааны эрх зүйн актыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон Мал эмнэлгийн ерөнхий газар, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газраас өгсөн чиглэлийн хүрээнд харьяалах сум, дүүргийн нутаг дэвсгэрт чиг үүргээ хэрэгжүүлнэ.

1.3. Сум, дүүрэг дэх мал эмнэлгийн тасаг нь харьяалах байгууллагын нэр, дугаар бүхий тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, бланк хэрэглэнэ.

Хоёр. Тасгийн бүтэц зохион байгуулалт

2.1. Сум, дүүрэг дэх мал эмнэлгийн тасаг нь тасгийн дарга буюу мал эмнэлгийн улсын байцаагч, тархвар зүйн гэсэн 2 орон тоотой ажиллана.

2.2. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.14, 7.15, 27 дугаар зүйлийн 27.7-д заасан мал эмнэлгийн хяналтын цэг харьяалах сум, дүүрэг дэх мал эмнэлгийн тасгийн бүтэцэд чиг үүргээ хэрэгжүүлнэ.

2.3. Сум, дүүргийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагаанд мөргөжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажиллана.

Гурав. Удирдлага, хэрэгжүүлэх арга хэмжээ

3. Мал эмнэлгийн тасгийн дарга нь мал эмнэлгийн улсын байцаагч байна. Тасгийн дарга нь аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газрын даргын өмнө ажлаа тайлагнана.

3.1. Тасгийн дарга нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналтыг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар саналаа дээд шатны мал эмнэлгийн байгууллагад хүргүүлэх;

3.1.2. Хорио цээр, хягаарлалтын дэглэмийн биелэлтэнд хяналт тавих, цагийн байдлын мэдээ, тайланг тухай бүр гаргуулан авах

3.1.3. Мал, амьтны шилжилт, хөдөлгөөн, тэдгээрийн гаралтай хүнсний болон хүнсний бус түүхийг эд бүтээгдэхүүнд хяналт тавих

3.1.4. Дээд шатны мал эмнэлгийн байгууллага, орон нутгийн төрийн захиргааны байгууллагатай бүх талаар хамтран ажиллах, тэдгээрийн харъяа байгууллагад дэмжлэг үзүүлж, шаардлагатай мэдээ мэдээлэлээр хангаж ажиллах;

3.1.5. Мал эмнэлгийн нэгжийн үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах.

3.1.6. "Мал эмнэлгийн ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журам"-ыг үйл ажиллагаандаа баримтлан холбогдох бусад дүрэм, журмаар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд акт, албан шаардлага, улсын байцаагчийн дүгнэлт гаргах, шийтгэл өгөдгүүлэх;

3.1.7. Байгууллагын үйл ажиллагааны тайлан мэдээг байгууллагын хэмжээнд нэгтгэн гаргах, хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу мэдээлэх;

3.1.8. Байгууллагын үйлчилгээний стандарт, мал эмнэлгийн байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг чанд мөрдүүлж хэвшүүлэх, иргэн хуулийн этгээдэд үйл ажиллагаагаа сурталчлах;

3.1.9. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал, ашиглалтад хяналт тавих;

3.1.10. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагаатай холбоотой ёс зүй, зан харьцааны талаар иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг зохих журмын дагуу ханан шийдвэрлэх;

3.1.10 Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдтэй гэрээ байгуулан ажиллах, заавар зөвлөгөө өгөх, хяналт тавих;

3.1.11. Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Төрийн хяналт, шалгалтын тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль тогтоомж дүрэм журмаар олгосон бусад чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах;

3.1.12. Малын эмчийн итгэмжлэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох дүгнэлтийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шийдвэрлүүлэх

3.1.13. Мал, амьтны халдварт өвчин тараах, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэлтэй мал, амьтан тэдгээрийн гаралтай хүнсний болон хүнсний бус түүхийг эд зах зээлд нийлүүлэхийг хориглох, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхийг

таслан зогсоох, орноо эд рийн н пта д ор улах, шаардлагатай т х т гдлолд халдварг үртэх, тгээх

3.2 Мал эмнэлгийн төс" тархвар зүйч дара ь чиг ү ргийг хэрэгж үүнэ.

3.2.1 Тархвар үйнесүд алаанд үндэслэн харуулан нутаг дэвсгэртээ хад ар, шимэгчтэх өвчөөс ү үрчилэн сэтгүүлэх, эмчлэх арга хэмжээ -төтөй юм, хэрэгжүүлэх арга хэ мэ зохион байгуулах;

3.2.2. Тархвар зүйн судалгааны дүнд тулгуурлан сум, дүүргийн тархвар зүйн зураглал гаргах, холбогдох мэдээллийг халдварт өвчин гарсан үед өдөр тутам, халдварт өвчингүй, тайаан үед Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 8.1-д заасан төлөвлөгөөний дагуу улирал тутам харьяалах дээд шатны байгууллагад хүргүүлэх

3.2.3. Халдварт, гол халдварт өвчинтэй тэмцэх бэлэн байдлыг хангаж, идэвхитэй, идэвхгүй тандалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.2.4. Малын вакцин, биобэлдмэлийн захиалга хийж, зарцуулалтын гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль, дүрэм, журам, зааврын дээд шатны байгууллагад тайлагнах ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх;

3.2.5. Шаардлагатай статистикийн мэдээллийг харьяалах нутгийн захиргааны байгууллагаас гаргуулан авах

3.2.6. Мал эмнэлгийн үзлэг, лабораторийн шинжилгээ хийлгэх ажлыг зохион байгуулах

3.2.7. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах талаар гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч, малчид, мал бүхий иргэд, хуулийн этгээдийг мэргэжил, арга зүй, удирдлагын зөвлөгөө зөвлөмжөөр хангаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн ажиллах;

3.2.8. Малчин, мал бүхий иргэдэд мал эмнэлгийн чиглэлийн хууль тогтоомж, журмын талаар сургалт, сурталчилгааг тухай бүр хийх

3.3. Харьяалах мал эмнэлгийн газар, сум дүүргийн Засаг даргын тамгын газар, түүний харьяа болон дэргэдэх төрийн захиргааны байгууллагын нэгж, иргэн, аж ахуйн нэгжид тангидцуулга, тайлан, санал, хүсэлт, мэдээлэл, мэдэгдэл хүргүүлэхэд Мал эмнэлгийн тасгийн нэр бүхий хөвлөмөл албан хуудас, индекс дугаар бүхий тэмдэг хэрэглэж, тасгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

3.4. Тасгийн даргын түр зэгүйд түү ий алба үүргийг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын даргын шийдвэрээр харьяал (сум, дүүрэг дэм мал эмнэлгийн тасгийг тархвар зүйч орон гүйцэтгэнэ. Ажил рлон гүйцэтгэхийг албан бичгээр албажуулна.

Дөрөв. Мал эмнэлгийн тасгийн албан тушаалтны ангилал

4.1 Мал эмнэлгийн тасагт дараах төрийн захиргааны албан тушаалтан ажиллана.

4.1.1 Тасгийн дарга, мал эмнэлгийн улсын байцаагч ЛТЗ-6/

4.1.2 Тархвар зүйч ЛТЗ-5/

4.2. Албан тушаалтныг дараах эрх бүхий этгээд томилж чөлөөлнө.

4.2.1 Энэ дүрмийн 4.1.1-д заасан албан тушаалтныг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.3-т заасны дагуу аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын дарга томилж чөлөөлнө.

4.2.2 Энэ дүрмийн 4.1.2-т заасан албан тушаалтныг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын дарга томилж чөлөөлнө.

4.3 Албан тушаалтан нь мал эмнэлгийн салбарын хууль тогтоомж мал эмнэлгийн ерөнхий газрын даргын тушаал, шийдвэр дүрэм, журмыг баримтлан, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллана.

Тав. Мал эмнэлгийн тасгийн санхүүжилт

5.1 Мал эмнэлгийн тасаг нь ба улсын, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газрын төсвөөс санхүүжин үйл ажиллагаа явуулна.

Зургаа. Үйл ажиллагаагаа тайлагнах

6.1 Мал эмнэлгийн тасаг нь үйл ажиллагаагаа тогтоосон хугацаанд тайлагнана.

Долоо. Бусад

7.1 Энэхүү дүрэмд Ерөнхий газрын даргын тушаалаар өөрчлөлт оруулж болох бөгөөд энэхүү өөрчлөлт оруулсан бол холбогдох бичиглэлд мэдэгдэж бүртгүүлнэ